



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/253

Есөнбулаг сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн "Хөхморьт сумын дотуур байрны хайс"-ны ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	А.Алтанхуяг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүдэд:	П.Ганхуяг	(Аймгийн Төрийн архивын хэлтсийн ахлах архивч)
	Г.Батмагнай	(Хөхморьт сумын Засаг даргын орлогч)
	М.Энх-Орчлон	(Орон нутгийн өмчийн газрын Хууль, хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод хяналт шалгалтын мэргэжилтэн)
	Ц.Гэрэлцэцэг	(Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын сургуулийн захирал)
	Ж.Бодьгэрэл	("Үнэлэмж алтай" ХХК-ийн захирал)
Нарийн бичгийн дарга:	Г.Лхагвабаатар	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын хяналтын гэрээт инженер)

2. Барилга байгууламжийн засварын ажлыг ашиглалтад оруулахдаа Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг мөрдөн гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдэлтэй нийцүүлэн шалгаж, хүлээн авч, үр дүнг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг комисс (А.Алтанхуяг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ

